

**Монголын Олбсрлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
Ажлын хэсгийн хурлын протокол**

Улаанбаатар хот, Монголын Үндэсний Уул уурхайн ассоциацийн хурлын танхим  
2008 оны 08-р сарын 27-ны өдөр

**Хэлэлцсэн асуудлууд:**

1. ОУИТБС-ын хүрээнд тайлангаа гаргасан 28 компаниудын тайлангийн Засгийн газраас гаргасан тайлантай нэгтгэсэн тухай ажлын үр дүн, тайлан /МНБИ-ийн ерөнхийлөгч Дондог, мэргэжилтэн Жаргалсайхан/
2. 2007 оны тайлангийн нэгтгэл хийх ажлын шалгаруулах удирдамжийг хэлэлцэх, батлах / Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон /
3. ХБНГУ-ын Берлин хотноо болох ОУИТБС-ын семинарт оролцох хүмүүсийн нэрсийг батлах /Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон зохицуулна/

Ажлын хэсгийн хурал УУҮА-н байранд 2008 оны 08-р сарын 27-ны өдрийн 15 цагт эхэлж 18 цаг 00 минутад дуусав. Хуралд ажлын хэсгийн 23 гишүүн оролцох ёстой байсан боловч 15 гишүүн оролцож ирц 65,2 %-тай байлаа.

**Хуралд оролцсон :**

1. Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр
2. Үндэсний татварын ерөнхий газрын дарга, Ажлын хэсгийн гишүүн Л. Зориг /орлож хэлтсийн дарга Энхтуяа/
3. Айвенхоу майнз компанийн дэд ерөнхийлөгч, Ажлын хэсгийн гишүүн А.Мөнхбат-г /орлож дэд захирал Ц. Содхүү/
4. Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга, Ажлын хэсгийн гишүүн н.Билэгсайхан /орлож мэргэжилтэн Цэгц/
5. Улсын мэргэжлийн хяналтын газрын дэд дарга, Ажлын хэсгийн гишүүн Г.Зянаамядар /орлож Мөнхбаяр/
6. БОЯ-ны ХБОБНГ-ын дарга, Ажлын хэсгийн гишүүн Ц. Банзрагч
7. Нээлттэй нийгэм форумын менежер, Ажлын хэсгийн гишүүн Н. Дорждарь
8. Байгаль хамгаалах ТББ-уудын холбооны тэргүүн, Ажлын хэсгийн гишүүн Ж. Батболд
9. Ил тод сангийн тэргүүн, Ажлын хэсгийн гишүүн Ц. Ганболд
10. Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал, Ажлын хэсгийн гишүүн Н. Алгаа
11. Нүүрс ассоциацийн тэргүүн, Ажлын хэсгийн гишүүн Л. Даваацэдэв /орлож ажилтан Ганзориг/

12. Информ төвийн гүйцэтгэх захирал, Ажлын хэсгийн гишүүн Р. Батпүрэв
13. Бороо гоулд компанийн дэд захирал, Ажлын хэсгийн гишүүн н. Сандаг /орлож компанийн ажилтан Тулгаа/
14. Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын ерөнхийлөгч, Ажлын хэсгийн гишүүн Л.Дондог
15. Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын аудитын чанарын мэргэжилтэн Жаргалсайхан
16. Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын аудитын чанарын мэргэжилтэн .....
17. ЗГХЭГ-ын ахлах референт, ОУИТБС-ын Ажлын хэсгийн н/б/д Э.Сумъяа
18. ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон
19. ОУИТБС-ын Ажлын албаны санхүүгийн ажилтан Т. Хүрэлчимэг

Д. Батбаяр: За та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Ажлын хэсгийн өнөөдрийн хурлаар ОУИТБС-ын 2006 оны нэгтгэсэн тайланд ороогүй 28 компанийн тайланд МНБИ-ийн аудит хийсэн дүгнэлтийг сонсох, мөн 2007 оны ОУИТБС-ын тайлангийн нэгтгэл хийх аудитын компанийг шалгаруулах ажлыг үндэслэлээр батлах, хэргэнд болох ОУИТБС-ын семинарт оролцох хүмүүсийн нэрсийг батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэнэ. За МНБИ-ээс хийсэн аудитын дүгнэлтийг эхлээд сонсоцгооё.

МНБИ-ийн ерөнхийлөгч Дондог тайлангийн танилцуулгыг хийв.

Д. Батбаяр: Аудитын дүгнэлт дээр асууж тодруулах зүйл байна уу?

Ц. Ганболд: За би хэдэн зүйл тодруулмаар байна. Нэгд, ээрт энэ 28 компаниудыг ямар шалгуураар сонгож авсан бэ? Тэр олдохгүй байгаа гээд байгаа 28 компани нь үнэхээр байршилдаа байхгүй байна уу, олдохгүй байна уу? Хүснэгтүүд дээр ойлгомжгүй юм бас байнаа. 28 компанийн тайлан гэсэн мөртлөө зарим төлбөр дээр 25,26 болоод явчихсан байна. Энэ ямар учиртай юм бол?

Л.Дондог: Сүүлийн асуултыг тодруулахад хүснэгтэн дээр зөвхөн зөрүүтэй дүнгүүдийг нь бичсэн байгаа.

Э. Сумъяа: Эхний асуултанд хариулъя. Энэ 28 компанийг ямар нэгэн сонгон шалгаруулалтаар аваагүй ээ. Харьцуулж болох 2 талын тайлантай нь нийт 53 байсан юм. Үүний 25-ыг нь аудитын нэгтгэлд оруулаад үлдсэн 28 компанийг нь МНБИ-ээр шалгуулсан. Ийм л учиртай юм.

Л. Дондог: Тэр хаяг бүртгэл нь тодорхойгүй 6 компанийн тухайд бидэнд үнэндээ олдоогүй ээ. Татвараас хаяг тодруулсан боловч тэр хаяг нь хуучирсан байсан.

Батпүрэв: Энэ тайланг буруу мэдээлсэн тохиолдолд хүлээх ямар нэгэн шийтгэл байдаг уу? Хуулинд заасан юм байгаа юу?

Л. Дондог: Үүнийг хуулиар зохицуулаагүй байгаа учир ямар нэгэн шийтгэл энэ тэр байхгүй байгаа.

Батболд: Энэ ажлын явцад ер нь компаниуд зохих ёсоороо татвараа төлж байгаа эсэхийг тодруулах боломж байна уу?

Л. Дондог: Ийм зүйл ажлын удирдамжинд ороогүй . Ер бол давхар шалгаад явчих боломжтой.

Энхтуяа: Энэ тайлан бол бидний эхний тайлан байсан учраас хамгийн гол нь компаниудын төлсөн гэсэн дүнг цуглуулах маань л чухал байсан. Дараа дараагийн тайлан дээр бол төлөх ёстой, төлсөн гэсэн дүнгүүдийг гаргаад явах боломжтой гэж бодож байна.

Ганболд: Их өвөлжөө ХХК олдохгүй байсан гэж Дондог гуай хэлсэн. Би үүнд итгэмээргүй санагдаад байна л даа. Энэ компани чинь Шарын голд олборлолт хийдэг, 5-6 лицензтэй, өөрөө ганц лицензээ ашигладаг, бусдыг нь хувь хүмүүст түрээслүүлдэг газар л даа. Тэгэхээр бид энэ ил тод байдал гэдгийг бүрэн утгаар хэрэгжүүлбэ гэвэл нэгдсэн бүртгэл тооцоо, хаяг бүртгэл, тэр лиценз эзэмшдэг болон ашигладаг хүмүүсийг нь бүртгэдэг тогтолцоог ажиллуулмаар байна. АМГТХЭГ болон ҮТЕГ 2 уялдмаар байна.

Энхтуяа: Татварт анх олборлох үйлдвэрлэл эрхэлнэ гэж 360 орчим компани бүртгүүлснээс 2006 онд 137 нь үйл ажиллагаа явуулж татвараа төлсөн байдаг. Хаяг бүртгэлийн тухайд 7 хоногт 50 компани бүртгүүлдэг учир татварын байцаагч тэр хаягандаа байгааг нь очиж үзэж үнэхээр амждаггүй ээ. Нэгдсэн бүртгэлийн хувьд бид/ҮТЕГ/ АМГТХЭГ-тай улирал тутам бааз солилцож мэдээллээ шинэчилж байгаа. Энэ бол ямар ч байсан эхний алхам болж байгаа.

Банзрагч: Компаниудын тайланг дотоодын аудитын компаниар хийлгэсэн маань ер нь их ач холбогдол сайнтай, үр дүнтэй болсон гэж үзэж байна. Ер нь Монголд монгол хүмүүс л сайн ажиллана шүү дээ.

Батболд: Энэ тайлангаас тэгээд авлига энэ тэр нь тодорхой гарсангүй ш дээ. Хэлбэр талаас нь анхаарах хэрэгтэй санагдаж байна.

Д. Батбаяр: За дараагийн асуулагдаа оръё. 2007 оны тайланд аудит хийх аудиторыг ямар шалгуураар сонгох вэ гэсэн асуудлыг Цолмон танилцуулна.

2007 оны тайлангийн нэгтгэл хийх ажлын шалгаруулах удирдамжийн төслийг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав.

Ш. Цолмон: За энэ төсөл дээр та бүхний саналыг сонсох гэсэн юм.

Ц. Ганболд: Монголын компанийг, эсвэл монгол компанитай хамтран орох консорциумыг сонгохоор тийм шалгуур байх хэрэгтэй байна. Монголын аудиторуудыг чадваржуулахад ч энэ бас ач холбогдолтой. Тэгээд ч өөрсдөө хийж чадаж байгаа юмаа заавал гадаадын өндөр үнэтэй, монголын нөхцлийг мэдэхгүй хүмүүсээр хийлгэх шаардлагагүй гэж үзэж байна.

Ц. Содхүү: Үүн дээр Дэлхийн банкттай сайн ярилцаад үзвэл тохиролцох боломжтой гэж үзэж байна. Түүнээс гадна ажлын хэмжээ үнэ хоёрыг нь Монголын компанид тохируулаад л заачихвал гадаадын компани бага гэж голоод орж ирэхгүй байлгүй дээ.

Ш. Цолмон: Дэлхийн банкны журмаар Чанар ба үнэнд суурилсан аргаар сонгон шалгаруулалтыг хийх юм. Энэ нь эхлээд санхүүгийн саналыг биш тендерийн материалыг шалгаруулаад, шалгарсан компаниуд дундаасаа бага үнэтэйг нь сонгох арга юм. Тэгэхээр үнийг урьдчилан зарлах боломжгүй болохоор нөгөө өндөр үнэтэй гадаад компаниуд чинь л үлдэх магадлал өндөр л дээ.

Дорждарь: Би 2006 оны нэгтгэлийг хийх тендерийн хороонд орж ажилласан. Тэгэхэд аудитын компаниудаас аль гайгүй материал бэлдсэнийг нь л шалгаруулсан. Шалгуурт нь Монголд ажилласан туршлагатай гэж байгаагүй. Аудиторууд нь шинэ жилийн үед ирсэнийг ч хэлэх үү, бас учраа олохгүй хугацаа их алдсан тал байгаа.

Сумъяа: Дэлхийн банкнаас манай аудитын санхүүжилт гарч байгаа болохоор өөрсдийн аудитын дагуу сонгон шалгаруулахаас өөр зогсоогүй байгаа. Бидний үгнээс ДБ хүлээж авах ч юм байна, авахгүй ч юм байна. Тэрнийг бид мэдэхгүй шүү дээ.

Энхтуяа: Бид одоо хүн болгон л өөр өөр юм ярьж байна. Энэ удирдамжинд тусгуулах өөрсдийн саналуудаа албан ёсоор и-мэйлээр явуулчихвал яасан юм бэ.

Бүгд: Тэгье.

Ганзориг: Гадаад оас нэг санал байна. Нэгэн ил тод байдлыг дэмжих талаар ярьж байгаа юм чинь компаниудаас ирүүлсэн 2007 оны тайлангуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлүүлчихвэл яаж байна?

Бүгд: Дэмжиж байна.

Алагаа: ОУИТБС-ын тайланг гаргах гэсээр байтал 2 жил өнгөрч, мэдээллийн ач холбогдол нь алдагдчих гээд байна. Энэ мэдээж аудитор сонгон шалгаруулах Дэлхийн банкны дүрэм журмаас болж хугацаа шаардагддаг тал байгаа л байх. Тиймээс Засгийн газраас энэ зардлыг санхүүжүүлэх боломж байгаа юу.

Сумъяа: Бид 2009 оны улсын төсөвт баталгаажуулалтын зардал зэрэг хэдэн төгрөг суулгах саналаа өгчихсөн л байгаа. Ер нь бодож байгаа асуудал.

Д. Батбаяр: Зөв сүүлийн асуудалдаа орчло. Энэ 11 сард ХБНГУ-д зохиогдох ОУИТБС-ын семинарт хэн хэнийг оролцуулах вэ гэдэг саналаа Ш. Цолмонд өгөх юм байна.


Ш. Цолмон: Оролцогч 3-н талаас 3,3-н хүний нэрийг дэвшүүлээд Явуулах юм. Тэгээд тэндээс 3 хүнийг нь шалгаруулж семинарт оролцуулна. Бид талуудаас дэвшүүлсэн 9 хүний нэрсийг та бүхэнд тараасан байгаа. Өөр санал байвал өгнө үү.

Бүгд: Зөвшөөрч байна.

Д. Батбаяр: За тэгвэл өнөөдрийн хурлаа өндөрлөө. Хуралдаа ирсэн та бүхэнд баярлалаа.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөл,  
Ажлын хэсгийн ахлагч Д. Батбаяр



Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОУИТБС-ын Ажлын албаны  
ажилтан Т. Хүрэлчимэг

